

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР**  
**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ гаргах заалт**  
**/ 2023 оны I, II сарын тайлан мэдээ /**

2023.03.06

Улаанбаатар хот

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	2023 оны I, II сарын хэрэгжилтийн үр дүнгийн тухай мэдээлэл	Хэрэгжилтийн үнэлгээ					30 болон 0 үнэлгээтэй бол удааширсан шалтгаан		Хэрэгжилтийн явц	
			100	70	30	0	ХБ	Санхүүжилтээс	Зохион байгуулалтаас	Үрт хугацаанд хэрэгжих	Бүрэн хэрэжсэн

**ЗГ-ЫН ТОГТООЛ**

"Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2022-04-06 Дугаар 2022_143	<p>2. Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших "Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.</p> <p>2. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, эх үүсвэрийн зураг төслийг боловсруулах болон барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах болон гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим</p>	<p>Шинэ Зуунмод /Аэро сити/ хот нь Засаг захиргааны нэгжийн статусын хувьд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг тул Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг чиг үүргийн дагуу Барилга хот байгуулалтын яам болон Төв аймаг хариуцсан ажиллана.</p> <p>Хариуцсан чиг үүрэг биш тул хасуулах саналтай байна.</p>
---	---	---

	хүчний сайд Н.Тавинбэх, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт даалгасугай.							
Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	1.2. байнгын ашиглалтад хүлээн авсан орон сууцны хороолол, цогцолборын хэмжээнд барилгын норм, дүрмийн шаардлага хангасан цэцэрлэг төлөвлөгдөн баригдсан эсэхэд үзлэг хийж, дунг танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт;	Tус газрын чиг үүрэгт хамааралгүй заалт тул хасах саналтай.						
	1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг теслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2022 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Боловсрол, шинжлэх ухааны сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар "Орон сууцны зориулалттай барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэгийн салбар бүлэг байгуулах үйл ажиллагааны тур журам"-ыг баталсан бөгөөд Хан-Уул дүүрэгт 4 байршилд 450 хүүхдийн хүчин чадалтай, Сонгинохайрхан дүүрэгт 1 байршилд 50 хүүхдийн хүчин чадалтай, нийт Нийслэлийн хэмжээнд 5 байршилд 500 хүүхдийн хүчин чадалтай Цэцэрлэгтэй орон сууцны барилгын загвар зураг батлагдсан. Дээрх батлагдсан загвар зургийн дагуу магадлал хийгдсэн ажлын зургийг үндэслэн Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ одоогоор олгогдоогүй байна.	+	+				
	1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан,	Tус газрын чиг үүрэгт хамааралгүй заалт тул хасах саналтай.						

	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p> <p>2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд "түр цэцэрлэг" байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар баталсан "Орон сууцны зориулалттай барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэгийн салбар булэг байгуулах үйл ажиллагааны түр журам"-ыг баримтлан Нийслэлийн хэмжээнд 5 байршилд 500 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгтэй орон сууцны барилгын загвар зураг батлагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хан-Уул дүүрэгт 4 байршилд 450 хүүхдийн хүчин чадалтай;</li> <li>- Сонгинохайрхан дүүрэгт 1 байршилд 50 хүүхдийн хүчин чадалтай.</li> </ul>	+	+				
	<p>3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Улаанбаатар хотын хэмжээнд хийгдэж байгаа дараах хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан нийгмийн дэд бүтэц /сургууль, цэцэрлэг, эмнэлэг/-ийг төлөвлөн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</li> <li>- Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол</li> <li>- "Амгалан" дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл</li> </ul>	+	+				



барж байгуулах тухай 2022-12-21 Дугаар 2022_476	шаардлагатай техникийн нөхцөлийг шуурхай олгож ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, холбогдох байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.	хүртэлх 64.05 км авто зам, замын байгууламжийн төлөвлөх даалгавар батлагдсан.									
	5. Авто замын чигийн дагуух ногоон байгууламж, инженерийн болон цахилгааны шугам, сүлжээ, гэрэлтүүлэг, холбооны кабелийг зөөх, шилжүүлэх, хүчинтгэх, хамгаалах ажлыг 2023 оны 4 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт, уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	2023 онд нийт 84 ажлын зураг төсөл зөвшүүлцсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- Цахилгаан хангамжийн 58 ажлын зураг;</li><li>- Холбооны худаг сувагчлалын 26 ажын зураг.</li></ul>	+								+

## ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

<p>2021 оны 2 дугаар сарын 3-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2021-02-08 Дугаар 2021_8</p>	<p>I.4. 1. иргэдийг орон сууцжуулах асуудлаар санал солилцох, уулзалт зохион байгуулах болон орон сууцны хороолол барих байршлыг газар дээр нь судалж, нэг маягийн зураг төслеөр барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт;</p>	<p>Сургууль, цэцэрлэг, ерхийн эмнэлэг, хорооны байр гэх мэт Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн зураг төслийг нэг маягийн зургаар боловсруулан батлуулах ажлыг Барилга, хот байгуулалтын яам болон чиглэлийн холбогдох яамдууд хариуцах бөгөөд Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын чиг үүрэгт хамааралгүй болно. Барилга байгууламж баригдах байршлыг захиалагчийн зүгээс тодорхой болгосон тохиолдолд тухайн байршилд нэг маягийн зургаар баригдах барилгын Архитектур</p>
--	--	---

		төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг хянан баталдаг. <b>Хасуулах саналтай байна.</b>								
2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2021-11-03 Дугаар 2021_58	XII.6.3. 2002 оноос өмнө баригдсан нийтийн зориулалттай барилга байгууламжийг паспортжуулах, гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга) нарт;	2023 оны 02 дугаар сарын байдлаар 17 барилгад дүгнэлт гаргаж паспортжуулсан.		+		+				
2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47	IX.1.5. "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм"-д заасан хүн ам, барилгажилтын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршиудыг тогтоож, орон сууц, олон нийтийн барилгын зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгох, шилжүүлэх, газрын талбайн хэмжээ, зориулалт, эдэлбэрийн хэлбэрийг өөрчлөх, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлах, түүнд өөрчлөлт оруулахыг "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" батлагдаж, дагаж мөрдөх хүртэлх хугацаанд түр хориглох талаар хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Нийслэлийн иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04"-д заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршиудад хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбай барихаас бусад зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгох, шилжүүлэх, талбайн хэмжээ, зориулалт, эдэлбэрийн хэлбэр өөрчлөх, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлах, түүнд өөрчлөлт оруулах үйл ажиллагаа явуулахыг хориглох шийдвэр гаргуулах талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн "Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04-д заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршиудыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар		+					+	
	IX.1.6. "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм"-д заасан хүн ам, барилгажилтын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршилд зөвшөөрөл олгосон барилгын ажлын хуульд заасан норм, шаардлага, стандартыг хангуулах, хэрэгжилтийн явцыг 2022 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;					УБ				

		хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.						
	IX.1.19. "Их тойруу" доторх 4 байршил, Улаанбаатар хот руу орох чиглэлийн 2 байршилд их багтаамжийн давхар зогсоол шинээр барьж, менежментийг сайжруулах ажлыг судалж, Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт 4 давхар 184 ширхэг авто машины зогсоолын барилга, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт 7 давхар бүхий 301 ширхэг авто машины авто зогсоол буюу Тохижилт бүхий их багтаамжийн авто зогсоолын барилгыг 2 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар болон загвар зураг батлагдсан.	+					+
	IX.1.21. "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний төслийг 2022 онд багтаан Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	- Барилга, хот байгуулалтын Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газарт өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэртэй холбогдуулан баримт материалын бүрдлийг хангуулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. - "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барилга, хот байгуулалтын Сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. УИХ-ын тогтоолын төсөлд тусгах саналыг Засгын газрын 16 яамдаас авч дууссан. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хулээгдэж байна.	+					+

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.БАДАМХАНД

НЭГТГЭСЭН: БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Л.ЭНХТУУЛ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Л.АДЬЯСҮРЭН